



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/166/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Д.Энхжаргал Утас: 70432545 Цахим хаяг: enkhjargald@audit.gov.mn</p>
--------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.18 № 2/40
танай _____-ны № _____-т

МЯНГАД СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ЯНЖИНЛХАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянгад сумын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 79,699.5 мянган төгрөгийн санхүүжилтээр сургуулийн хуучин спорт заалыг засварласан, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 17,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр спортын дэвжээ худалдан авч өгсөн байна.

Аудитын гол асуудал

Сургуулийн бүсийг утасгүй интернэтээр хангах, цахим анги байгуулах санхүүгийн түрээсийн гэрээг 36,525.0 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотойгоор өглөг өссөн байна.

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон хандиваар 273,008.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 137 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийг 94.0 хувийн биелэлтэй гэж дээд шатны төсвийн захирагчаас дүгнэсэн байна. Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1 дүгээр шатанд үнэлэгдэж 42,846.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	179,000,619.66	249,229,987.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	57,381,488.39	111,045,931.91
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	57,381,488.39	111,045,931.91
3121	Төгрөг	57,381,488.39	111,045,931.91
31211	Төрийн сангийн харилцах	57,381,488.39	111,045,931.91
33	АВЛАГА	3,657,711.43	3,014,294.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,619,111.43	852,474.00
335	Бусад авлага	38,600.00	2,161,820.00
3351	Байгууллагаас авах авлага	38,600.00	2,161,820.00
35	БАРАА МАТЕРИАЛ	117,961,419.84	135,169,762.04
351	Түүхий эд материал	62,618,795.43	62,618,795.43
35110	Тусгай зориулалттай материал	61,922,795.43	61,922,795.43
35130	Эм боох материал	696,000.00	696,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,362,476.00	6,401,796.00
354	Хангамжийн материал	50,980,148.41	66,149,170.61
35410	Бичиг хэргийн материал	500,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	39,112,850.67	52,422,651.27
35460	Хүнсний материал	6,353,227.53	4,367,997.13
35470	Бусад хангамжийн материал	5,014,070.21	9,358,522.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,197,530,556.62	2,419,075,441.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,197,530,556.62	2,419,075,441.34
392	Биет хөрөнгө	2,130,233,556.62	2,351,790,941.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,226,308,171.00	2,306,007,659.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-404,744,706.48	-452,663,389.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,775,760.00	4,775,760.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,775,760.00	-4,775,760.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	398,073,240.60	538,526,106.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-198,253,702.80	-230,676,125.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,034,104.31	193,523,329.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,337,390.76	-43,381,781.52
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	450,000.00	450,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,480,479.00	16,480,479.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,573,047.84	-2,721,746.40
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	25,796,409.59	26,246,409.59
393	Биет бус хөрөнгө	67,297,000.00	67,284,500.00
39301	Програм хангамж	875,000.00	875,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-512,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	66,922,000.00	66,922,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,376,531,176.28	2,668,305,429.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,861,137.17	19,319,107.61

Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг	2,861,137.17	19,319,107.61
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	517,078.44
4136	Бусад өглөг	2,861,137.17	18,802,029.17
41361	Байгууллагад төлөх өглөг	2,778,066.37	18,701,058.37
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	83,070.80	100,970.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,373,670,039.11	2,648,986,321.68
51	Засгийн газрын хувь оролцоо	2,373,670,039.11	2,648,986,321.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	640,569,994.00	640,569,994.00
512	Хуримтлагдсан үр дүн	636,920,048.32	912,236,330.89
51210	Өмнөх үеийн үр дүн	636,920,048.32	636,920,048.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	275,316,282.57
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,096,179,996.79	1,096,179,996.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,376,531,176.28	2,668,305,429.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,695,903,818.79	2,679,924,291.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,989,070.79	287,009,391.79
120	Нийтлэг татварын бус орлого	110,989,070.79	287,009,391.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	110,989,070.79	287,009,391.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	3,164,627.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	110,389,070.79	283,844,764.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,584,914,748.00	2,392,914,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	670,400.00	37,325,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	670,400.00	37,325,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	239,096,200.00	343,952,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	239,096,200.00	343,952,700.00
1330	Төсвийн захирагчдаас	1,345,148,148.00	2,011,637,200.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,344,597,500.00	2,011,637,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,585,947,577.73	2,404,608,009.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,585,947,577.73	2,404,608,009.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,533,413,079.80	2,295,357,936.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	975,869,221.07	1,506,721,792.91
210101	Үндсэн цалин	975,869,221.07	1,506,721,792.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,680,725.67	186,222,440.22
210201	Тэтгэврийн даатгал	114,117,598.67	186,222,440.22
210202	Тэтгэмжийн даатгал	8,563,127.00	00.00

Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	229,779,833.07	303,681,206.96
210301	Гэрэл, цахилгаан	7,607,159.07	18,340,322.66
210302	Түлш, халаалт	206,546,124.00	268,509,955.30
210303	Цэвэр, бохир ус	15,626,550.00	16,830,929.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,316,186.51	53,511,301.00
210401	Бичиг хэрэг	9,943,870.00	13,769,257.00
210402	Тээвэр, шатахуун	3,100,770.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	21,271,546.51	39,742,044.00
2105	Нормативт зардал	66,605,619.76	71,631,370.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	616,600.00	00.00
210502	Хоол, хүнс	65,989,019.76	71,631,370.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,327,480.00	27,502,316.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,951,655.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,327,480.00	23,550,661.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,834,013.72	146,087,507.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,508,280.00	25,791,731.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	472,000.00	1,254,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,853,733.72	119,041,776.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,534,497.93	109,250,073.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,516,750.00	71,250,080.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,516,750.00	43,400,190.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	27,849,890.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,017,747.93	37,999,993.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,017,747.93	37,999,993.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	109,956,241.06	275,316,282.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,654,059.08	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,654,059.08	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,654,059.08	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	107,302,181.98	275,316,282.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,585,514,748.00	2,393,635,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	721,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	721,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	721,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	721,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,584,914,748.00	2,392,914,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	670,400.00	37,325,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	670,400.00	37,325,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	239,646,848.00	343,952,700.00

Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	239,096,200.00	343,952,700.00
1330	Төсвийн захирагчдаас	1,344,597,500.00	2,011,637,200.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,344,597,500.00	2,011,637,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,535,593,415.91	2,339,971,456.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,535,593,415.91	2,339,971,456.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,481,217,997.98	2,224,259,703.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	982,112,665.91	1,503,441,905.05
210101	Үндсэн цалин	651,960,745.59	837,178,376.28
210102	Нэмэгдэл	293,876,221.64	521,887,827.27
210104	Урамшуулал	36,275,698.68	144,375,701.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,928,900.00	186,259,210.67
210201	Тэтгэврийн даатгал	82,231,600.00	125,110,310.67
210202	Тэтгэмжийн даатгал	9,674,500.00	15,287,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,739,200.00	7,643,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,934,600.00	7,616,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,349,000.00	30,601,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,278,452.07	303,681,206.96
210301	Гэрэл, цахилгаан	8,478,659.07	15,889,500.00
210302	Түлш, халаалт	209,046,093.00	270,960,777.96
210303	Цэвэр, бохир ус	15,753,700.00	16,830,929.00
2105	Нормативт зардал	65,752,400.00	68,610,360.00
210502	Хоол, хүнс	65,752,400.00	68,610,360.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	2,271,500.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	2,271,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,327,480.00	35,791,549.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	12,240,888.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,327,480.00	23,550,661.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,018,100.00	124,203,971.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,467,300.00	110,715,671.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,550,800.00	13,488,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,375,417.93	115,711,753.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,357,670.00	77,711,760.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,357,670.00	49,861,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	27,849,890.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,017,747.93	37,999,993.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,017,747.93	37,999,993.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,921,332.09	53,664,443.52
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	49,921,332.09	53,664,443.52
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,460,156.30	57,381,488.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,381,488.39	111,045,931.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
					C01
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	573,647,994.00	222,541,583.00	-343,433,869.35	452,755,707.65
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,218,249.72	68,218,249.72
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	640,569,994.00	1,096,179,996.79	636,920,048.32	2,373,670,039.11
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	640,569,994.00	1,096,179,996.79	636,920,048.32	2,373,670,039.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	640,569,994.00	1,096,179,996.79	636,920,048.32	2,373,670,039.11
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	275,316,282.75	275,316,282.75
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	640,569,994.00	1,096,179,996.79	912,236,330.89	2,648,986,321.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
		1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,363,267,800.00	2,301,971,463.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,363,267,800.00	2,301,971,463.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,363,267,800.00	2,224,259,703.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,556,963,600.00	1,503,441,905.05
210101	Үндсэн цалин	979,785,700.00	837,178,376.28
210102	Нэмэгдэл	520,883,900.00	521,887,827.27
210104	Урамшуулал	56,294,000.00	144,375,701.50
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,429,000.00	186,259,210.67
210201	Тэтгэврийн даатгал	132,341,900.00	125,110,310.67
210202	Тэтгэмжийн даатгал	15,569,600.00	15,287,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,794,800.00	7,643,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,784,800.00	7,616,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,139,300.00	30,601,300.00

Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	343,952,700.00	303,681,206.96
210301	Гэрэл, цахилгаан	15,889,500.00	15,889,500.00
210302	Түлш, халаалт	304,936,800.00	270,960,777.96
210303	Цэвэр, бохир ус	20,826,400.00	16,830,929.00
2105	Нормативт зардал	85,190,000.00	68,610,360.00
210502	Хоол, хүнс	85,190,000.00	68,610,360.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	2,271,500.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,271,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,232,500.00	35,791,549.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,331,600.00	12,240,888.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,900,900.00	23,550,661.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,308,600.00	124,203,971.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,820,300.00	110,715,671.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,488,300.00	13,488,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,315,400.00	77,711,760.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,315,400.00	77,711,760.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,465,500.00	49,861,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,849,900.00	27,849,890.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,444,583,200.00	2,355,635,906.96
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,011,637,200.00	2,011,637,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,011,637,200.00	2,011,637,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	343,952,700.00	305,952,706.96
132001	Орон нутгийн төсвөөс	343,952,700.00	305,952,706.96
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	88,993,300.00	38,046,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,849,900.00	721,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,727,200.00	37,325,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	53,416,200.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	57,381,488.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	111,045,931.91
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	01.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	01.00
610001	Төсвийн байгууллага	00.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	56.00	56.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00.00	478.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	00.00	478.00
630001	Төрийн өмчит ЕБС	00.00	478.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	00.00	56.00

650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	56.00
--------	-----------------------------------------------------	-------	-------

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,716.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 168,039.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹ -г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Хүлээн авсан компьютер тоног төхөөрөмж 57,084.7 мянган төгрөгийн хөрөнгийг дансанд бүртгэлд тусгаагүй
- Өмнөх онд хүлээн авч бүртгэсэн 53,573.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг дахин бүртгэсэн
- Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 57,381.5 мянган төгрөгийг орлогоор бүртгэсэн

Залруулагдаагүй 5,677.1 мянган төгрөгийн 3 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,677.1 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 3,780.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1,897.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 *Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 3,780.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заалттай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Дотоод хяналттай холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын байгууллагад ажиллагсдын цалинг 1,897.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэггүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулах, тайлан мэдээг үнэн зөв гаргах

5.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургуулийн сургалтын менежер, багш нар, нийгмийн ажилтан, дотуур байрны багш нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажилтнуудын ур чадварыг ажлын хэсэг байгуулан тусгай шалгуураар үнэлж дүгнээгүй олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", БШУС, ХНХС, СС-ын хамтарсан 2021 оны 2 дугаар сарын 01-ны А/35/А10/9/ дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна..

Өгсөн зөвлөмж: Сургуулийн багш, сургалтын менежер, дотуур байрны багш нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо 3 сайдын хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу ажлын хэсэг байгуулан холбогдох заалтаар үнэлсний үндсэн дээр төсөв захирагч шийдвэр гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							тоо	Дүн	тоо	Дүн		
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Төслийн хөрөнгө оруулалтаар ирсэн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй	1	295,924.0					1	295,924.0				
	1	295,924.0					1	295,924.0				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй	1	640.3	1	640.3							
Ур чадварын нэмэгдлийг журам зөрчиж илүү олгосон	1	9,383.5	1	9,383.5							
Хүлээж авсан сурах бичгийг дутуу бүртгэсэн, Түрээсийн сурах бичгийн тооцоо хийгээгүй, орлогыг төвлөрүүлээгүй	1	2,495.6					1	2,495.6			
Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй 8408000802 нэгж талбарын дугаар бүхий 1000 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр олгогдож газар эзэмшүүлэх гэрээ хийгдсэн ч газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй	1	0					1	0			
	4	12,519.4	2	10,023.8			2	2,495.6			